

*Отгонтэнгэр их сургуулийн
Эрдмийн зөвлөлийн 2019 оны 04
дүгээр сарын 11-ний өдрийн
хурлаар хэлэлцэн батлав.*

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛИЙН ДОКТОРЫН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД БАРИМТЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Дээд боловсролын тухай хууль, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/370 тоот тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”, Отгонтэнгэр их сургуулийн /цаашид ОТИС гэх/ дүрмийг үндэслэн докторын сургалтыг ОТИС-д зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Тус сургуулийн докторын сургалтын агуулга нь магистрын зэрэгтэй мэргэжилтнийг элсүүлэн шинжлэх ухааны тодорхой чиглэлээр гүнзгийрүүлсэн сургалтад хамруулж эрдэм шинжилгээний ажил бие дааж гүйцэтгэх хүн өөрийгөө хөгжүүлэхэд мэдлэг, чадвар, дадал, ёс зүйг эзэмшин, мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэхэд чиглэнэ.

1.3. Докторын судалгааны ажил нь тухайн салбар, шинжлэх ухааны практикт тулгамдсан асуудлыг дэвшүүлэн тавьж, түүнийг тал бүрээс нь судлан боловсруулж дүгнэсэн тухайн салбарт шинэ мэдлэг бүтээхэд тодорхой хувь нэмэр оруулсан судалгаа шинжилгээний бие даасан бүтээл байна.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт

2.1. Докторын сургалтыг ОТИС-ын сургалтын нэгдсэн алба эрхлэн явуулна. Сургалтын нэгдсэн алба нь ОТИС-ийн дүрмийн дагуу байгуулагдсан Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирлын удирдлага дор үйл ажиллагаа явуулдаг сургуулийн сургалтын үндсэн нэгж болно.

2.2. Сургалтын нэгдсэн алба нь дарга, бүтцийн сургууль хариуцсан менежерүүдээс бүрдэнэ. Эрдэм шинжилгээ, судалгааны төв нь суралцагчдад судалгааны арга зүйн зөвлөгөө өгч, их семинарыг зохион байгуулж, эрдэм шинжилгээний ажлын мэдээллийн сан бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх ажлыг хариуцна.

2.3. Сургалтын нэгдсэн алба нь хэрэгжүүлж байгаа докторын хөтөлбөр тус бүрээр түүнийг боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн болон чанарын удирдлагаар хангаж, тухай бүр үнэлгээ хийх үүрэг бүхий хөтөлбөрийн дэд хороо ажиллуулна.

2.4. Сургалтын нэгдсэн алба нь ОТИС-ийн эрдмийн зөвлөл, бүтцийн сургууль, Эрдэм шинжилгээ судалгааны төв, докторын хөтөлбөрийн дэд хороод болон бусад сургуулийн докторын зэрэг хэрэгжүүлэх хөтөлбөр, хамгаалуулах зөвлөлүүдтэй нягт хамтран ажиллаж сургалт, судалгааны ажлын чанарыг сайжруулах, цаашид хөгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллана.

2.5. Сургалтын нэгдсэн алба нь докторын зэргийн сургалтыг нэгдсэн удирдлагаар хангах, сургалт, судалгаа, профессор, оюутны болон санхүүгийн үйл

ажиллагаанд чанарын хяналт тавих, докторын зэрэг хамгаалах зөвлөл байгуулах ажлыг зохион байгуулна.

2.6. Сургалтын нэгдсэн албаны үйл ажиллагааны зардал нь ОТИС-ийн нэгдсэн төсөвт жил бүр тусгагдана. Төсвийн зарцуулалтын асуудлыг ОТИС-ийн захирлын тушаалаар зохицуулна.

2.7. Сургалтын нэгдсэн алба нь дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.7.1. ОТИС-ийн стратеги төлөвлөгөө болон ОТИС-ийн Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг хөгжүүлэх 2018-2022 оны хөтөлбөртэй уялдуулан энэхүү журамд заасны дагуу докторын сургалтыг зохион байгуулж, докторантын суралцах орчин, судалгаа хийх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.7.2. докторын сургалтад суралцагчийн оролцоог дэмжсэн, хөтөлбөрт суурилсан, хурдавчилсан, идэвхтэй арга хэлбэрээр болон цахимаар зохион байгуулж болно.

2.7.3. докторын судалгааны ажил нь зохиогчийн эрхийн зөрчилтэй эсэхийг шалгах зорилгоор бүтээлийн хуулбарлалт илрүүлэх /plagiarism detector/ систем бүрдүүлж, журмаар зохицуулна.

2.7.4. сургалтын үйл ажиллагааны хүрээнд докторын сургалтын хөтөлбөр шинээр нээх, хаах, оюутан элсүүлэх, кредит цагийн биелэлт, чанарт хяналт тавих, оюутан төгсгөх, туслах /дагалдан/ багшаар ажиллуулах /бакалаврын сургалтад оролцуулж цалин урамшуулал олгох/ болон оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

2.7.5. судалгааны үйл ажиллагааны хүрээнд докторантын эрдэм шинжилгээний ажлын чанар, үр нөлөөг сайжруулах, судалгааны туслахаар ажиллуулах /судалгааны сэдэвт ажил, төсөлд оролцуулж цалин урамшуулал олгох/ хөтөлбөр хэрэгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглуулах, хэвлэн нийтлэх бодлогыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

2.7.6. хөтөлбөрийн дагуу сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны багц цагийг чанартай гүйцэтгэх, судалгааны ажилд тасралтгүй оролцох, судалгааны ажлын үр дүнгээ хэлэлцүүлж, хэвлэн нийтлүүлэх, сургалт, судалгааны ассистантшип хөтөлбөрт хамрагдах зэрэг магистрант, докторантын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах;

2.7.7. сургалт, судалгааны зардал, цагийн тооцоо, төлбөр, тэтгэлгийн тооцоо, хуваарилалт, зарцуулалт болон оюутны судалгааг дэмжих санхүүжилт, тэтгэлгийн сан бий болгох санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг санхүүгийн албатай хамтран зохион байгуулах.

Гурав. Докторын хөтөлбөрт тавигдах шаардлага

2.1. Багшлах бүрэлдэхүүн

2.1.1. ОТИС нь докторын зэргийн сургалтад хичээл заадаг багш нарт тухайн түвшний хөтөлбөр, сургалтын онцлог, хөдөлмөр зарцуулалт болон тэдний мэргэжлийн ур чадварт дүйцсэн цалин хөлс олгоно.

2.1.2. докторын сургалтад хичээл заах профессор багш нь тухайн чиглэлээр докторын зэрэгтэй, салбарын тэргүүлэх эрдэмтэн мэргэжилтэн байна.

2.1.3. докторантурын сургалтад гадаад хэлний хичээл заах багш магистрын зэрэгтэй байж болох ба тухайн хэлний чиглэлээр олон улсад хүлээн

зөвшөөрөгдсөн /TOEFL, IELTS, TESOL гэх зэрэг/шалгалтын хангалттай оноо авсан байна.

2.1.4. докторын сургалтад хичээл заадаг багш судалгаа шинжилгээний ажил эрхэлдэг байна. Багш нарт судалгаа шинжилгээний ажил эрхлэх боломж, нөхцөлийг холбогдох дүрэм журамд тусган бүрдүүлнэ.

2.1.5. докторын судалгааны ажлын удирдагч багш нь БСШУ-ны сайдын 2014 оны А/370 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Магистр, Докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”-ын 2-р зүйлийн 2.8.2 болон 2.8.3-д заасан шалгуурыг хангасан байна.

2.1.6. докторантын элссэн улиралд багтаан мэргэжлийн тэнхим, оюутны саналд тулгуурласан бүтцийн сургууль суралцагч нэг бүрээр эрдэм шинжилгээний ажлын удирдагчийг томилох саналыг боловсруулж захирлын тушаалаар баталгаажуулна.

2.1.7. ОТИС-ийн зөвлөх профессор болон докторын сургалтад идэвхтэй оролцдог, өөр байгууллагад судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхэлдэг, докторын зэрэгтэй хүн докторын сургалтад хичээл зааж, удирдагчаар ажиллаж болно.

2.1.8. удирдагч профессор нь дараах үүрэгтэй байна.

2.1.8.1. докторын судалгааны ажлын бүтэц, агуулгын багтаамж, арга зүйг тодорхойлоход зөвлөмж өгөх, суралцагчийн судалгааны дизайн, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах,

2.1.8.2. диссертацийн төлөвлөгөөний биелэлтийг хянаж, туршилт судалгаа хийх, задлан шинжлэх, туршилтын дүнг боловсруулахад арга зүйн туслалцаа үзүүлэх, өгүүлэл бичих, илтгэл тавих зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг удирдан чиглүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын багц цаг тооцох дүгнэлт гаргах

2.1.8.3. судалгааны ажил хийх болон судалгааны ажил бичих явцад тодорхой хуваариар мэргэжлийн зөвлөгөө өгч, хяналт тавих, судалгааны ажлын агуулгыг хэсэг бүрээр болон бүхэлд нь дүгнэх,

2.1.8.4. удирдсан судалгааны ажлыг хамгаалалтад оруулах тодорхойлолт бичиж, зөвшөөрөл өгөх,

2.1.8.5. эрдэм шинжилгээний болон профессорын хэлэлцүүлэг зохион байгуулах саналыг хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжид гаргаж докторантад уг семинарт судалгааны ажлынхаа үр дүнг илтгэн хэлэлцүүлж байх нөхцөлийг бүрдүүлэх,

2.1.8.6. профессорын хэлэлцүүлэг, урьдчилсан хамгаалалт, төлөвлөгөөт хэлэлцүүлэгт удирдагчийн хувьд оролцох, уг зөвлөлөөс гаргасан дүгнэлттэй танилцах

2.1.8.7. судалгааны ажлын үр дүн шинжлэх ухааны үнэн зөв байдлыг хангасан эсэх, хууль эрхийн хүрээнд хийгдсэн талаар хариуцлага хүлээж, тодорхойлолт гаргах

2.1.9. докторын судалгааны ажлын сэдэв нь шинжлэх ухааны 2-3 салбарт хамаарахаар бол 2 удирдагч томилж болно.

2.1.10. тухайн чиглэлээр докторын зэрэг хамгаалсан, өндөр ур чадвартай профессорыг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж зөвлөх болон зочин профессороор

урьж ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд албан ёсны гэрээ байгуулан ажиллуулна.

2.1.11. нэг профессорын удирдах докторантын тоо нэг хичээлийн жилд 2-оос илүүгүй байна.

2.1.12. удирдагч багшийн ажлын үр дүнг хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж болон хөтөлбөрийн дэд хороо, ЗХШҮА-аас жил бүр үнэлэх ба хүлээх хариуцлага, урамшууллын асуудлыг холбогдох журамд тусгана.

2.2. Сургалтын төлөвлөгөө

2.2.1. докторын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөнд хичээлийн нэр, багц цаг, хичээл хоорондын уялдаа холбоо болон хөтөлбөрт тавигдах шаардлагыг нарийвчлан тусгасан байна.

2.2.2. докторын сургалтын ердийн хугацаа өдрөөр суралцахад 3 жил, эчнээгээр суралцахад 4 жил, экстернат бол 1-2 жил байна. Судалгааны ажлыг хийж кредит цагаа бүрэн биелүүлсэн бол удирдагч, тэнхим, бүтцийн сургууль, сургалтын нэгдсэн албаны зөвшөөрлөөр сургалтын хугацааг 1 улирлаар богиносгож болно.

2.2.3. докторын сургалтын төлөвлөгөө нь 60 багц цаг байна. Мэргэжил болон хөтөлбөрийн онцлогоос хамааруулж сургалтын төлөвлөгөөний үзэх хичээл, эрдэм шинжилгээний цагийн харьцааг сургалтын нэгдсэн албаны шийдвэрээр өөрчилж болох ба эрдэм шинжилгээний ажлын багц цаг 12 багц цагаас бага байж болохгүй.

2.2.3.1. мэргэжлийн хичээл 12 багц цаг

2.2.3.2. мэргэших хичээл 18 багц цаг,

2.2.3.3. эрдэм шинжилгээний ажил 6 багц цаг,

2.2.3.4. докторын судалгааны ажил 24 багц цаг, нийт 60 багц цаг.

2.2.4. сургалтын төлөвлөгөөний агуулга:

2.2.4.1. мэргэжлийн заавал үзэх хичээл нь шинжлэх ухааны тухайн салбараар судлаач хүний эзэмшсэн байх мэдлэгийн түвшний жишгийг тогтоосон агуулгатай байна.

2.2.4.2. мэргэших хичээл нь нарийн мэргэжлээр судлаач хүний эзэмшсэн байх мэдлэгийн түвшний жишгийг тогтоосон агуулгатай байна.

2.2.4.3. удирдагч багшийн удирдлагаар бие даан судалж илтгэх, хичээлийн агуулгын зарим хэсгийг мэргэжлийн /удирдагчийн семинарт илтгэх, хэсэг бүлгээр хувааж реферат бичих, нөхцөлт судалгаа /case study/ хийх, төсөл хөтөлбөрт оролцох, шалгалт өгөх хэлбэрээр багц цагаа тооцуулахыг зөвшөөрнө.

2.2.4.4. суралцагч мэргэшүүлэх хичээлийн хүрээнд 6 багц цагийг бусад тэнхим, профессорын баг, бусад нэгж, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сонгон судална.

2.2.5. докторантын эрдэм шинжилгээ, судалгааны багц цагийг “Магистрант, докторантуудын эрдэм шинжилгээ, судалгааны багц цаг тооцоход баримтлах журам”-ын дагуу тооцож, баталгаажуулна.

2.2.6. докторын сургалтын төлөвлөгөөг хамаарах хөтөлбөрийн дэд хороо боловсруулж, сургалтын нэгдсэн алба хянах ба эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжсэн бол ОТИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна. Ингэхдээ ОТИС-ийн сургалтын нэгдсэн албаны боловсруулсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загварыг баримтална.

2.2.7. суралцагч бүр судлах хичээлийг сонгож, ганцаарчилсан төлөвлөгөө гарган сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирлаар батлуулах ба сургалтын нэгдсэн алба хуваарь гарган баталгаажуулж, гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.

2.2.8. мэргэжлийн тэнхим сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээл бүрээр судлах агуулгыг боловсруулж, гүйцэтгэлийг хянаана.

2.2.9. өдрөөр суралцагч нэг улиралд 10, эчнээгээр суралцагч 6-аас ихгүй багц цагийн хичээл судална. Эрдэм шинжилгээний багц цагийн гүйцэтгэлд хязгаар тогтоохгүй.

2.2.10. докторын хөтөлбөрт заавал судлах хичээлийг зааж болно.

2.2.11. экстернат хэлбэрээр суралцах докторантын мэргэших хичээлийн 18 хүртэлх багц цагийг бүтээлүүдээр нь дүйцүүлэн тооцож болно. Дүйцүүлэн тооцож болох цагийг эрдэм шинжилгээ, сургалт эрхэлсэн дэд захирлын томилсон комисс үнэлж, захирлын тушаалаар батлуулна.

2.2.12. дүйцүүлэн тооцох бүтээлд дараах бүтээл хамаарна. Үүнд:

2.2.12.1. үр дүн нь докторын судалгааны ажлын эхэд орохгүй, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэн нийтлүүлсэн өгүүлэл,

2.2.12.2. их сургуулийн сурах бичиг, хэвлүүлсэн монограф, нэг сэдэвт бүтээл

2.2.12.3. зохион бүтээсэн багаж төхөөрөмж, тогтоосон стандарт, патент, оюуны эрх авсан бүтээл

2.2.12.4. байгуулсан эрдэм шинжилгээний лаборатори, эрдэм шинжилгээний музей,

2.2.12.5. зарим боловсруулалт /компьютерын программ, газрын зураг/карт, хуулийн төсөл, бизнесийн кейс судалгаа албан ёсоор улсын хэмжээнд мөрдөж буй аргачлал, стандарт гэх мэт/.

2.3. Хичээлийн хөтөлбөр

2.3.1. мэргэжлийн тэнхим сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл бүрээр судлах агуулгыг багтаасан сургалтын хөтөлбөр боловсруулж, гүйцэтгэлийг хянаана.

2.3.2. хичээлийн хөтөлбөр нь дараах бүтэцтэй байна.

- хичээлийг заах багшийн нэр, эрдмийн зэрэг цол, харилцах хаяг
- хичээлийн нэр, код, багц цаг
- хичээлийн зорилго
- хичээлийг судалснаар хүрэх үр дүн/мэдлэг, чадвар, дадал/
- хичээлийн залгамж холбоо
- хичээлийн товч тодорхойлолт
- хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, агуулга /өдөр бүрээр төлөвлөсөн судлах зүйлийн тойм/
 - сургалтад ашиглах эх сурвалж, /үндсэн болон нэмэлт ном, нэг сэдэвт бүтээл, интернэт эх сурвалж гэх мэт/
 - гүйцэтгэх даалгавар, үнэлэх, дүгнэх арга хэлбэр, үнэлгээний хуваарь
 - хичээлийн хөтөлбөрийн чанарын баталгаажилт

2.3.3. докторын хичээлийн хөтөлбөрийг тухайн хичээлийг заах профессор багш боловсруулж, хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцүүлэн батална.

2.4. Төгсөгчдийн эзэмших ур, чадвар

2.4.1. хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, дадал, төлөвшил

- шинийг эрэлхийлэх, асуудал шийдвэрлэх чадвар. /асуудлыг тодорхойлж, баримт нотолгоонд үндэслэн дүн шинжилгээ хийж, зүй тогтлыг илрүүлэх, тандан судлах, хөгжлийн хандлагыг тодорхойлох, шинэ санаа гаргах, зураглах, боломжит хувилбарыг сонгож илэрхийлэн харуулах/

- шинжлэн судлах, шийдэл гаргах /таамаглал дэвшүүлэн харьцуулсан судалгаа, анализ хийх, загварчилж баримт бичиг боловсруулах/

- системтэй төлөвлөх /Мэргэжлийн сэтгэлгээгээр хандах, хоорондоо хамааралтай зүйлсийг бүхлээр нь олж харах, харилцан хамаарлыг нь ойлгох, ач холбогдлоор нь ангилан чухал санаан дээр төвлөрч шалгах, харьцуулан сонгох/

- хувь хүний ур чадвар ба дадал /шинийг санаачлах эрмэлзэлтэй, уламжлалыг дээдлэн уян хатан бүтээлч сэтгэлгээтэй байх, хувь хүний мэдлэг, ур чадвар, төлөвшлийг үнэлж ухамсарладаг, бие даан суралцах, цагийн болон нөөцийн менежментийг зөв хэрэгжүүлдэг байх/

- мэргэжлийн ур чадвар, төлөвшил /мэргэжлийн болон судлаачийн ёс зүйтэй, хариуцлагатай, чадвартай, эдийн засгийн тооцоотой байх, тасралтгүй судалгаа хийж, идэвхтэй бүтээлч судлаач байж шинэ мэдлэг, мэдээллийг бий болгон шинжлэх ухаанд хувь нэмрээ байнга оруулах/

2.4.2. харилцааны ур чадвар /багаар ажиллах чадвар ба харилцаа/

- багаар ажиллах /баг бүрдүүлэх, багийг удирдах, нөлөө үзүүлэх, төслийн менежментийг хэрэгжүүлэх, манлайлах ур чадвартай байх/

- харилцааны чадвар /харилцааны стратеги, бүтцийг ойлгодог, бичгийн, электрон, мультимедиа, график дүрслэлээр болон яриа, бичгээр тайлагнах, хүнтэй харилцах үндсэн ур чадвартай байх/

- гадаад хэлээр харилцах /англи болон бусад гадаад хэлээр мэргэжлийн мэдээлэл ашиглах, санаа бодлоо илэрхийлэх, илтгэх, бичих чадвартай байх/

- хөтөлбөрөөр суралцсан төгсөгчийн загвар, Мэргэжлийн хичээлээр эзэмших мэдлэг, чадамж, түүнийг шалгах шалгуур үзүүлэлтийг хөтөлбөрийн дэд хороо тодорхойлон батлуулж ажиллана.

2.5. Суралцагчийн үнэлгээ

2.5.1. хичээл бүрийн үнэлгээний зэрэгцээ хөтөлбөрийн үндсэн үе шат бүрийн үр дүнг дараах хэлбэрээр үнэлнэ.

- явцын үнэлгээ
- улирлын үнэлгээ
- ур чадварын үнэлгээ
- бусад үнэлгээ

2.5.2. үнэлгээ нь суралцах үйл явцыг дэмжсэн бодитой, үнэлгээний нийтлэг жишигтэй харьцуулах боломжтой байна.

2.5.3. хөтөлбөрийн үр дүн нь мэргэжлийн эрх олгохтой холбогдох тохиолдолд харгалзах мэргэжлийн шалгалтын үнэлгээний аргачлалтай нийцэхүйц байна.

2.5.4. сургалтын төлөвлөгөөнд заагдсан зарим хичээлд С буюу түүнээс дээш дүн авсан байх шаардлага тавьж болно.

2.6. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт

2.6.1. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хөтөлбөрийн хороо хагас жил тутамд үнэлж сургуульдаа тайлагнаж байна. Энэхүү үнэлгээний хүрээнд дараах чиглэлээр судалгаа хийж дүгнэн шинжилнэ.

- сэтгэл ханамжийн үнэлгээ /суралцагчид, төгсөгчдөөс/
- явцын үнэлгээ/суралцагчийн ахиц дэвшилд үе шаттай хийх үнэлгээ/
- гүйцэтгэлийн үнэлгээ /ажил олгогч, мэргэжлийн хөндлөнгийн үнэлгээ/
- үр нөлөөний үнэлгээ /мэргэжлийн салбар дахь нөлөөллийг үнэлэх/
- хөтөлбөрийн санхүүгийн байдлын үнэлгээ /чанарын үнэлгээ, судалгааг/
- хөтөлбөрийн чанарын үнэлгээ /чанарын үнэлгээ, судалгааг тодорхой үе шат давтамжтайгаар хийж үр дүнг хөтөлбөрийг хөгжүүлэх, сайжруулах бодлого шийдвэрт ашигладаг байх/

2.6.2. хөтөлбөрийг хэрэгжүүлэх тусгай зөвшөөрөл авснаас хойш 5 жилийн дотор магадлан итгэмжлэгдэнэ.

2.7. Элсэлт

2.7.1. сургалт эрхлэх зөвшөөрөл авсан докторын хөтөлбөрөөр, докторант оюутан элсүүлэх бөгөөд докторын сургалтад элсэгч тухайн мэргэжлээр магистрын зэрэгтэй байна. Элсэгч өмнө эзэмшсэнээс өөр чиглэлээр докторын хөтөлбөрт хамрагдах бол сургалтын агуулгын чанарыг хангахад шаардагдах хичээлийн зөрүүг нөхөн үзнэ. Нөхөж үзсэн хичээлийг докторын хөтөлбөрийн үндсэн багц цагт тооцохгүй.

2.7.2. жил бүрийн докторын хөтөлбөрөөр элсэгчийн элсэлтийн шалгалтыг ОТИС-ын захирлын тушаалаар байгуулсан элсэлтийн комисс зохион байгуулна.

2.7.3. энэ журмын 3.7.3-т заасан болзол, шаардлагыг хангасан докторын хөтөлбөрт элсэх хүсэлтэй хүн дараах материалыг бүрдүүлж сургуулийн докторын сургалтын элсэлтийн комисст ирүүлнэ. Үүнд:

- өргөдөл,
- анкет,
- дипломын нотариатаар батлуулсан хуулбар /эх хувийг шалгах/
- цээж зураг 4%,
- иргэний үнэмлэхийн хуулбар
- хэрвээ судалгаа шинжилгээ хийж байсан туршлагатай бол бүтээлийн жагсаалт, ном бүтээл зэрэг материалуудыг бүрдүүлэн сургуулийн захиргаанд ирүүлнэ.

2.7.4. докторын хөтөлбөрийн элсэгч нь тухайн мэргэжлийн чиглэлээр элсэлтийн шалгалт өгнө.

2.7.5. мэргэжлийн шалгалт бичгийн болон ярилцлагын гэсэн хэлбэрээр 2 үе шаттай байна. Элсэгч өмнө эзэмшсэнээс өөр чиглэлээр докторын хөтөлбөрт хамрагдах бол сургалтын агуулгын чанарыг хангахад шаардагдах хичээлийг зөрүүг нөхөн үзэж шалгалтыг дахин өгч болно.

2.7.5.1. бичгийн шалгалтаар тухайн элсэгчийн судалгааны сэдвийн үндэслэл, ач холбогдлыг илэрхийлсэн сэдэмж бичүүлнэ. Элсэлтийн комисс сэдэмжийн дагуу шалгуулагчийн сонгосон судалгааны сэдвийн чиглэлийн

профессор багштай сэдвийн тулгамдсан байдлыг хэлэлцэж, эхний шатны шалгаруулалтыг хийнэ.

2.7.5.2. элсэлтийн комисс эхний шалгаруулалтад тэнцсэн шалгуулагчтай ярилцлага хийж, шаардлага хангасан шалгуулагчийг докторантаар элсүүлэн авна.

2.7.6. ОТИС-ийн захирлын тушаалаар батлагдсан элсэлтийн комисс докторын хөтөлбөрт элсэгчдийн өргөдөл, элсэлтийн шалгалт, ярилцлагын үр дүн, мэргэжлийн тэнхимийн санал зэргийг үндэслэн тухайн өргөдөл гаргагчийг элсүүлэх тухай шийдвэр гаргана. Уг шийдвэрт үндэслэн захирлын тушаал гарган баталгаажуулна.

2.7.7. элсэлтийн шалгалтад тэнцсэн тохиолдолд суралцагчид кредит тооцох дэвтэр олгоно.

2.7.8. элсэгч өмнө эзэмшсэн бакалавр ба магистрын мэргэжлээс өөр чиглэлээр докторын сургалтад хамрагдах бол сургалтын агуулгын залгамж чанарыг хангахад шаардагдах зөрүү гарсан хичээлийг нөхөн үзнэ. Нөхөн үзэх хичээлийн багцыг мэргэжлийн тэнхим мэргэжлийн бэлтгэл хөтөлбөр болгон боловсруулж хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцэн батална.

2.7.9. докторын сургалт Үндсэн ба цагийн /өдөр, эчнээ, экстернат/ хэлбэртэй байна.

2.7.10. дараах болзол хангасан хүнийг экстернат докторантаар суралцуулна. Үүнд:

2.7.10.1. их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад сургалт, эрдэм шинжилгээний ажлыг 6-аас дээш жил хийсэн туршлагатай,

2.7.10.2. эрдэм шинжилгээ, сургалтын 15-аас доошгүй бүтээл хэвлэн нийтлүүлсэн. Үр дүн нь судалгааны ажилд орохгүй судалгааны бүтээлүүд нь мэргэжлийн ба мэргэшүүлэх хичээлүүдийн багц цагтай дүйцүүлэн тооцох боломжтой,

2.7.10.3. агуулга нь докторын судалгааны ажлын 75-аас дээш хувийг хангахуйц бүтээл бичиж бэлэн болгосон

2.7.10.4. экстернатаар суралцахыг хүссэн хүний эрдэм шинжилгээний ажлын агуулга, чанар, үр дүнгийн талаар үнэлгээ өгч, бүтээлээр нь тооцох багц цаг тодорхойлж, суралцах болзол хангасан тухай сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирлын томилсон комисс шийдвэр гаргаж, захирлын тушаалаар баталгаажна.

2.7.11. гадаадын их сургуультай 1:1 хэлбэрийн хамтарсан хөтөлбөр, докторын дараах сургалт, судлаач оюутан солилцох хөтөлбөр хэрэгжүүлж, ОТИС докторын хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион явуулж болох ба хөтөлбөр боловсруулах, сургалтын агуулгыг тодорхойлох, докторант сонгох, тэдний суралцах нөхцөлийг хангах асуудлыг тусгай журмаар зохицуулна.

2.7.12. гадаадын иргэнийг сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээгээр докторын солилцооны хөтөлбөрт суралцуулна.

2.7.13. докторант нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сургууль хаясан, сургуулийн дотоод журмыг зөрчсөн, суралцах хугацааны төлбөрийг төлөөгүй, төлөвлөгөөнд заасан кредитийг хангаагүй бол ОТИС-ийн захирлын тушаал гарган докторантураас хасна.

2.8. Сургалтын хугацаа

2.8.1. докторын сургалтын ердийн хугацаа өдрөөр суралцахад 3 жил, эчнээгээр суралцахад 4 жил, экстернат бол 1-2 жил байна

2.8.2. хичээлийн нэг жил нь 15 долоо хоног бүхий 2 улиралтай байна. Хичээлийн жил болон улирлын график, календарьчилсан төлөвлөгөөг сургалтын нэгдсэн алба гаргаж, суралцагчдад хүргэсэн байна.

2.8.3. докторант нь элссэнээс хойш 30 хоногийн дотор сургалтын гэрээ байгуулж, тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрөө төлсөн байна.

2.8.4. сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн 20 багц цагийг судалсны дараа гадаад хэлний нэгдсэн шалгалтыг зохион байгуулна. Нэгдсэн шалгалтыг ОТИС-ийн захирлын тушаалаар томилогдсон комисс авах бөгөөд нэгдсэн шалгалтыг А /4,0/, А- /3,6/, В /3,1/, В- /2,7/, /С /2,3/, С- /1,9/, D /1,4/, D- /1,0/, F үнэлгээгээр дүгнэх бөгөөд D буюу түүнээс доош оноо авсан суралцагч гадаад хэлний зохих сургалтад хамрагдан дахин шалгалт өгнө. Энэхүү давтан сургалтын хугацаа болон багтаамж нь сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан үндсэн багц цагт тооцогдохгүй ба нэмэлт кредитийн төлбөрийг докторант төлнө. Гадаад хэлний сургалтыг докторантын ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах замаар хугацааг товлон суралцана.

2.8.5. докторант судалгааны ажлаа эхлүүлэхийн өмнө мэргэжлийн чиглэлээр мэдлэг, бие даасан судалгаа явуулах чадварыг нотлох зорилго бүхий нэгдсэн шалгалт өгнө. Нэгдсэн шалгалтыг тухайн чиглэлийн хөтөлбөрийн хорооны санал болгосны дагуу ОТИС-ийн захирлын тушаалаар баталсан холбогдох мэргэжлийн 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй комисс авна. Мэргэжлийн нэгдсэн шалгалтыг мэргэжлийн хичээл болон мэргэших хичээлийн агуулгаар авна. Энэхүү шалгалтын дүн, сургуулийн журмаар тогтоосон бусад шаардлагыг хангасан байдлыг үндэслэн нэгжээс судалгааны ажлаа эхлүүлэх албан ёсны зөвшөөрөл олгоно. Нэгдсэн шалгалтад докторант хангалтгүй /F/ үнэлгээ авсан тохиолдолд дараагийн улиралд дахин 1 удаа өгөхийг зөвшөөрнө.

Дөрөв. Докторын судалгааны ажил бичих, хамгаалах, хүлээлгэн өгөх

4.1. Судалгааны ажлын сэдэв, төлөвлөгөө

4.1.1. докторант нь өөрийн сонирхсон сэдвээр судалгаа хийх, удирдагч багшаа сонгох тухай саналаа мэргэжлийн тэнхимд гаргах эрхтэй.

4.1.2. хөтөлбөрийг хариуцаж буй мэргэжлийн тэнхим сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд, нийгмийн ач холбогдолтой гэж үзсэн сэдвийн ерөнхий томьёолол, удирдагч багшийг докторантуудад санал болгоно. Докторант элссэнээсээ хойш 3 сарын дотор судалгааны ажлынхаа сэдвийг томьёолж бүтцийн сургуульд хүргүүлнэ.

4.1.3. бүтцийн сургууль нь докторант нэг бүрээр судалгааны сэдвийг томьёолж, тухайн сэдвээр мэргэшсэн эрдэм шинжилгээний ажлын удирдагчийг томилох саналыг боловсруулж сургалтын нэгдсэн албанд хүргүүлнэ.

4.1.4. сургалтын нэгдсэн албанаас удирдагч багшийг томилох саналыг боловсруулж ОТИС-ын захирлын тушаалаар баталгаажуулна.

4.1.5. суралцагч тус бүрийн докторын судалгааны ажлын сэдэв, удирдагч багш томилох саналыг хүлээн авснаас авснаас хойш 21 хоногийн дотор сэдэв, удирдагчийг томилно.

4.1.6. докторын судалгааны ажлын сэдэв, удирдагч албан ёсоор батлагдсаны дараа докторант бүр удирдагчтайгаа хамтран судалгааны ажлын ганцаарчилсан төлөвлөгөө гаргаж төлөвлөгөөний дагуу судалгааны ажлыг хийнэ.

4.1.7. судалгааны ажлын явц, удирдагч багшийн докторанттай хамтран ажиллах байдлыг үнэлэх товч тайланг докторант, удирдагч тус бүр хичээлийн жилийн эцэст тусгай маягтаар хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн эрхлэгчид ирүүлнэ. Тэнхимийн эрхлэгч тухайн маягтаар ирсэн мэдээллийг нэгтгэн дүгнэж, тайланг ЗХШҮА-д хүргүүлнэ.

4.1.8. ЗХШҮА нь докторант болон удирдагч багшийн хамтын ажиллагааны үр дүнг хичээлийн жилийн эцэст докторант болон удирдагч багшийн тайланд үндэслэн нэгтгэж сургалт эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захиралд тайлагнана.

4.2. Докторын судалгааны ажлыг хамгаалах

4.2.1. докторын судалгааны ажлын урьдчилсан хамгаалалт

4.2.1.1. удирдагч нь зөвшөөрсөн, ОТИС-ийн профессорын хэлэлцүүлгээр ажлаа амжилттай хэлэлцүүлсэн, гарсан санал шүүмжийн дагуу засварыг бүрэн хийсэн докторант ОТИС-ийн эрдмийн зөвлөлийн өргөтгөсөн хурлаар урьдчилсан хамгаалалт хийнэ. Тухайн хуралдааны өргөтгөсөн бүрэлдэхүүнд үндэсний хэмжээний хамгаалуулах зөвлөлийн гишүүдээс 3-аас доошгүйг урьж оролцуулахыг чухалчилна.

4.2.1.2. урьдчилсан хамгаалалтаар докторантын судалгааны ажилд мэргэжлийн дүгнэлт хийж, жинхэнэ хамгаалалтад оруулах тухай хуралдааны протоколоор баталгаажуулна. Энэ нь докторын ажил хамгаалуулах зөвлөлд ОТИС-оос гаргах хүсэлтийн нэг үндэслэл болно.

4.2.1.3. урьдчилсан хамгаалалтаас гарах шийдвэр нь докторантын судалгааны ажил сургалтын холбогдох журмын шаардлагыг хангасан, “ОТИС-ийн сургалтын хэрэглэгдэхүүн, судалгааны ажилд тавих ерөнхий шаардлага”-ын 2.2 дахь заалт, жинхэнэ хамгаалалтад орох шаардлага хангасан эсэх тухай байна.

4.2.1.4. урьдчилсан хамгаалалтад оролцсон багш, профессор, тухайн чиглэлийн үндэсний хамгаалуулах зөвлөлийн гишүүд докторантын судалгааны ажлын үр дүн, бичлэгийн шаардлага хангалтгүй, хэлэлцүүлгийн явцад гарсан санал шүүмж тухайн ажилд их хэмжээний засвар хийхээр нөхцөл үүсэх, судалгааны үр дүн, сэдвийн хувьд алдаатай гэж үзвэл тухайн ажлыг жинхэнэ хамгаалалтын шаардлага хангаагүй гэж үзэж, цаашид жинхэнэ хамгаалалтад оруулахыг зөвшөөрөхгүй тухай хурлын протоколоор баталгаажуулна.

4.2.2. докторын судалгааны ажлын хамгаалалт

4.2.2.1. докторын судалгааны ажлын жинхэнэ хамгаалалтыг БСШУ-ны сайдын баталсан “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”-д хамгаална. Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн хуралдаан 2010 онд батлагдсан “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-ээр зохицуулагдана.

4.2.2.2. докторын судалгааны ажилд хамгаалуулах зөвлөлөөс албан ёсны хоёр шүүмжлэгчийг томилно.

4.2.3. докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд ОТИС-оос гаргах хүсэлт

4.2.3.1. докторант сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, гадаад хэлний шалгалтаа амжилттай өгсөнтэй сургалтын төлөвлөгөөг докторын судалгааны ажлаа урьдчилсан хамгаалалтаар хэлэлцүүлсэн бол жинхэнэ хамгаалалтад орох зөвшөөрөл хүсэх өргөдлөө ОТИС-ийн Сургалтын нэгдсэн албанд уламжлах ба докторант дараах материалуудыг бүрдүүлж өгнө. Үүнд:

а. бакалавр, магистрын зэргийн дипломын хуулбар /нотариатаар баталгаажуулсан байх

б. бүтээлийн жагсаалт /удирдагч гарын үсэг зурж баталгаажуулсан байх/

в. докторантаар элссэн болон шилжилт хөдөлгөөн хийсэн тухай захирлын тушаал

г. батлагдсан сургалтын ганцаарчилсан төлөвлөгөө

д. сэдэв баталсан, удирдагч томилсон захирлын тушаал

е. дүнгийн нэгдсэн тодорхойлолт

ё. эрдэм шинжилгээ, судалгааны багц цаг тооцох комисс томилсон тухай эрдэм шинжилгээ, сургалт эрхэлсэн дэд захирлын шийдвэр, баг цаг тооцсон тухай комиссын шийдвэр

ж. төлбөрийн тооцоогүйг батлах баримт болон хамгаалалтын зардлыг тушаасан баримт

з. тэнхим нэгжийн хуваарьт хурал, эрдэм шинжилгээний их семинар, профессорын хэлэлцүүлгийн протокол

и. урьдчилсан хамгаалалт хийсэн протокол

к. урьдчилсан хамгаалалтаас гарсан санал шүүмжийг тусган судалгааны ажлыг зассан протокол, хүснэгт, баталгаажсан байх

л. докторын судалгааны ажлын хураангуй /3 хуудас танилцуулга англи хэлээр/

м. жинхэнэ хамгаалалтад орох шаардлага хангасан гэж үзсэн удирдагчийн тодорхойлолт

н. хамгаалалтад оруулахыг хүссэн хувийн өргөдөл

о. докторын судалгааны ажлын эх хувь

Хамгаалалтад оруулахыг зөвшөөрсөн тухай сургуулийн тодорхойлолтыг дээрх материалуудыг бүрдүүлсэн тохиолдолд гарган Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд илгээнэ.

4.2.3.2. докторын судалгааны ажил нь тухайн салбар шинжлэх ухааны практикт тулгамдсан асуудлыг дэвшүүлэн тавьж, түүнийг тал бүрээс нь судлан боловсруулж дүгнэсэн тухайн салбарт шинэ мэдлэг бүтээхэд тодорхой хувь нэмэр оруулсан судалгаа шинжилгээний бие даасан, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл байх шаардлагыг хангасан байна.

4.2.3.3. докторант сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, гадаад хэлний шалгалтаа өгсөн, сургалтын төлбөрөө төлсөн, докторын судалгааны ажлаа тэнхим/профессорын баг, ОТИС-ийн Эрдэм шинжилгээний их семинар, эрдмийн зөвлөлөөр урьдчилсан хамгаалалт хийн хэлэлцүүлсэн тухай ОТИС-ийн сургалтын нэгдсэн албаны дүгнэлт гарган докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд уламжилна.

4.2.3.4. докторант нь судалгааны ёс зүйг чандлан сахиж, зохиогчийн эрхийг зөрчөөгүй байна. Зохиогчийн эрхийн зөрчил илрүүлэх программаар 30-аас дээш хувийн зөрчилтэй гарсан бүтээлийг зөрчил арилгах хугацаа өгч бүтээлийг сайжруулахыг шаардана. Тухайн хугацаанд зөрчил арилсан бол энэ журмын 4.2.2-т заасны дагуу докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд уламжилна.

4.2.3.5. харин 50-ас дээш хувийн зөрчилтэй гарсан бүтээлийг докторын зэрэг олгох хамгаалалтад орох зөвшөөрөл олгохгүй.

4.2.3.6. докторын зэрэг горилсон судалгааны ажлын урьдчилсан хамгаалалтыг ОТИС-ийн эрдмийн зөвлөлийг мэргэжлийн эрдэмтдээр өргөтгөн хэлэлцүүлнэ. Урьдчилсан хамгаалалтын товыг нийтэд зарлаж, нээлттэй хийнэ.

Урьдчилсан хамгаалалтаар судалгааны ажилд мэргэжлийн дүгнэлт хийж, хуралдааны протокол гаргах ба энэ нь докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд ОТИС-аас гаргаж өгөх дүгнэлтийн нэг үндэслэл болно.

4.2.3.7. докторын судалгааны ажлыг ОТИС-ийн сургалт, судалгааны ажлын стандартын дагуу бичиж, хэвлүүлнэ.

4.2.3.8. докторын судалгааны ажлаа тухайн мэргэжлийн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хэлэлцүүлсэн боловч зөвшөөрөөгүй, хойшлуулсан болон бусад шалтгаанаар хамгаалж чадаагүй тохиолдолд дахин нэг удаа тус зөвлөлд хэлэлцүүлэх эрхтэй.

4.2.3.9. дахин хамгаалалтад орох хүсэлтээ докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн даргад гаргаж шийдвэрлүүлнэ.

4.2.3.10. докторын судалгааны ажлыг монгол хэлээр бичнэ. Судалгааны ажлын товч танилцуулгыг англи хэлээр 3 хуудаст багтаан бичиж, хавсаргана. Горилогчийн хүсэлт, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн дийлэнх олонхын зөвшөөрснөөр докторын судалгааны ажлыг англи хэлээр бичүүлж, хамгаалалтыг англи хэлээр явуулж болно. Энэ тохиолдолд докторын судалгааны ажлын товч танилцуулгыг монгол хэлээр бичнэ

4.3. Докторын судалгааны ажил хүлээлгэн өгөх

4.3.1. докторын судалгааны ажлын оюуны өмчийн эрх нь түүнийг бичсэн докторант болон ОТИС-д хамаарагдана.

4.3.2. оюутны бичиж амжилттай хамгаалсан докторын судалгааны ажлыг тогтоосон журмын дагуу бүрэн эхээрээ үдэгдсэн байдлаар сургуулийн архивд хадгалах буюу 1-2 хувийг сургуулийн номын санд шилжүүлж нийтийн хүртээл болгоно. Дипломын эх ажлыг оюутнуудад олноор нь болон хоногоор өгч явуулахыг хориглоно

4.3.3. эрдэм шинжилгээ, судалгааны төвийн эрхлэгч докторын судалгааны ажлаар мэдээллийн электрон сан үүсгэж, жил бүр баяжуулан хадгална. Энэхүү санг бүрдүүлэх, докторантуудад үйлчлэх ажлыг Эрдэм шинжилгээ, судалгааны төв хариуцан гүйцэтгэнэ.

4.4. Докторын зэрэг олгох

4.4.1. докторын судалгааны ажлыг амжилттай хамгаалсныг баталсан докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн ОТИС-ийн захирал докторын зэрэг олгох тушаал гаргана. Энэхүү тушаалыг үндэслэн сургалтын нэгдсэн алба докторын зэрэг олгосон дипломыг бичиж, гардуулах ажлыг зохион байгуулна

Тав. Сургалтын зардал

5.1. Докторантурт суралцагсдын төлбөрийн хэмжээг сургуулийн удирдах зөвлөлийн хурлаар жил бүр шинэчлэн тогтоож мөрдөнө.

5.2. Суралцаж буй улирлын сургалтын зардлыг хичээл эхэлснээс хойш 30 хоногт багтаан сургуулийн дансанд тушаасан байна. Сургалтын зардлаа хүндэтгэх шалтгаангүйгээр хугацаанд нь төлөөгүй докторантыг цаашид суралцуулахыг хориглоно.

5.3. Суралцагч төлбөрийг улирал, жилээр төлж болох ба энэ тухай бүрэлдэхүүн сургуулийн захиргаатай байгуулах гэрээнд нарийн тусгана.

5.4. Суралцагч сурлага, сахилгаар хасагдах болон хүсэлтээрээ чөлөөлөгдөх үед улс, захиалагч байгууллагаас төлсөн зардлыг буцааж төлөх болбол түүнийг суралцагч өөрөө хариуцна

5.5. Суралцагч нь суралцах хугацаандаа сургуулийн дотоод журмын хүрээнд ОТИС-ийн номын сан, компьютерын болон эрдэм шинжилгээ, судалгааны төв болон холбогдох багаж хэрэгслийг ашиглах эрхтэй.

5.6. Докторантаар хичээл заалгах, докторантын төлбөрийг хөнгөлөх, тэтгэлэгт хамруулах, профессорын гүйцэтгэж байгаа эрдэм шинжилгээний сэдэвт ажил, төсөлд докторантыг ажиллуулж судалгааг санхүүжүүлэх чиглэлээр удирдагч багш, профессорын баг/тэнхим, сургууль санаачилгатай ажиллах үүрэг хүлээнэ.

Зургаа. Номын сан, мэдээллийн бааз

3.1. ОТИС-ын номын сан болон Эрдэм, шинжилгээ, судалгааны төвийн бичил номын сан нь докторын сургалт явуулж буй чиглэлүүдээр мэргэжлийн сэтгүүл захиалдаг, интернэтэд холбогдсон, мэргэжлийн сэтгүүл, ном зүйн лавлагаа, нэг сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний цувралын сангаар хангах үүрэг хүлээнэ.

3.2. Сургалтын нэгдсэн алба нь докторантыг сургуулийн орчинд интернэт ашиглах боломжоор хангана.

3.3. ОТИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төвөөс эрхлэн гаргадаг “Отгонтэнгэр” эрдэм шинжилгээний бичиг нь ОТИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл байна.

3.4. “Отгонтэнгэр” эрдэм шинжилгээний бичгийн редакцын зөвлөлөөс судалгааны ажлын шаардлага хангасан гэж үзсэн тохиолдолд докторант нь өөрийн судалгааны ажлын чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны ажлын тойм зэргийг ОТИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлж болно.